

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4-р сарын 29-ны өдөр

Дугаар 01/25

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн саналын
дүнг батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Монноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01/25 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын Т-01/25 тоот тэмдэглэлийн шийдвэр хэсгийн 1 дүгээрт заасныг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 174986 санал буюу 98%-ийн саналаар Компанийн 2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг баталсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, “Компанийн тухай хууль”-ийн 83 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлж, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ТУЗ-д сар бүр ажлаа дүгнүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-д үүрэг болгосугай.

Хурлын дарга

Б.Алтангэрэл

Тооллогын комиссын дарга

Д.Даваасүрэн



“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4-р сарын 29-ны өдөр

Дугаар 02/25

Улаанбаатар хот

Компанийн удирдлагыг сонгож
батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дугаар заалт, “Монноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01/25 тоот тогтоол, ХЭХ-ын Т-01/25 тоот тэмдэглэлийн шийдвэр хэсгийн 2 дугаарт заасныг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн
184545 кумулятив санал буюу 11%-ийн саналаар С.Мөнхжаргалыг,
174986 кумулятив санал буюу 11%-ийн саналаар Ж.Болдбаатарыг,
175491 кумулятив санал буюу 11%-ийн саналаар С.Алимааг,
185307 кумулятив санал буюу 12%-ийн саналаар М.Тунгалагийг,
180179 кумулятив санал буюу 11%-ийн саналаар П.Оюунбаярыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн энгийн гишүүнээр,
174986 кумулятив санал буюу 11%-ийн саналаар Билл Холдсвортыг,
174986 кумулятив санал буюу 11%-ийн саналаар Б.Мэдрээг,
174986 кумулятив санал буюу 11%-ийн саналаар И.Сэр-Одыг,
182006 кумулятив санал буюу 11%-ийн саналаар Т.Батмагнайг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосныг тус тус баталсугай.
2. “Компанийн тухай хууль”-ийн 76 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, компанийн үйл ажиллагааг удирдлага хяналтаар хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга /Билл Холдсворт/-д зөвшөөрсүгэй.

Хурлын дарга

Б.Алтангэрэл

Тооллогын комиссын дарга

Д.Даваасүрэн



“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4-р сарын 29-ны өдөр

Дугаар 03/25

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах ТУЗ-ийн
шийдвэрийг дэмжих тухай

“Компанийн тухай хууль”-ийн 46 дугаар зүйл, компанийн ногдол ашгийн бодлогын тухай журам, ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 02/25 тоот тогтоолоор гаргасан шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01/25 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын 01/24 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 3 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн удирдлагын зардлын төсвийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 174986 санал буюу 98%-ийн саналаар 2024 оны ногдол ашгийг нэгж хувьцаанд 80 төгрөгөөр тогтоосон ТУЗ-ийн 02/25 тоот тогтоолыг дэмжсүгэй.
2. Ногдол ашигт зарцуулагдах 28,070,160 /Хорин найман сая далан мянга нэг зуун жаран/ төгрөгийг компанийн ашгаас гаргахыг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-т зөвшөөрсүгэй.
3. Компаниас гаргах мөнгөн хөрөнгийг 2025 оны 5 дугаар сарын 31-ны дотор Ногдол ашигийг нийтэд зарлан, тараах ажлыг зохион байгуулан гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-т даалгасугай.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



Б.Алтангэрэл

Д.Даваасүрэн

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4-р сарын 29-ны өдөр

Дугаар 04/25

Улаанбаатар хот

Компанийн удирдлагын зардлыг
батлах тухай

“Компанийн тухай хууль”-ийн 62.1.13 дугаар зүйл, хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01/25 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын 01/25 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 3 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн удирдлагын зардлын төсвийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 174986 санал буюу 98%-ийн саналаар 4,200,000 төгрөг /Дөрвөн сая хоёр зуун мянган/-өөр баталсугай.
2. Батлагдсан төсөвт багтаан компанийн удирдлагын зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-д, зардлын зарцуулалтын үнэн зөв байдалд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг ТУЗ-ийн дарга /Билл Холдсворт/-д тус тус даалгасугай.

Хурлын дарга

Б.Алтангэрэл

Тооллогын комиссын дарга

Д.Даваасүрэн



Д.ДАВААСҮРЭН
Б.МӨНХТУУЛ
Б.ЭНХДАРЬ

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН
ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр

Дугаар 02/25

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн саналын
тооллогын дүнг батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 63 дугаар зүйлийн 63.4, 63.5 дугаар заалт, 72 дугаар зүйлийг удирдлага болгон Монноос ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар өгсөн нууц санал хураалтанд явуулсан тооллогын дүнгийн тухай тооллогын комиссын 01/25 тоот тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 174986 санал буюу 98%-ийн саналаар Гүйцэтгэх захирлын Үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны тайланг, 174986 санал буюу 98%-ийн саналаар ТУЗ-аас компанийн Үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг батлах саналын дүнг баталсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн 174986 санал буюу 98%-ийн саналаар ТУЗ-ийн 2025 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 02/25 тоот тогтоолоор баталсан 2024 оны ногдол ашгийг нэгж хувьцаанд 80 төгрөгөөр буюу 28.070.160 төгрөг /Хорин найман сая далан мянга нэг зуун жаран/-ийг хуваарилахаар шийдвэрлэсэн шийдвэрийг дэмжсэн саналын дүнг,
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын кумулятив 184545 санал буюу 11%-ийн саналаар С.Мөнхжаргалыг, кумулятив 185307 санал буюу 12%-ийн саналаар М.Тунгалагийг, кумулятив 175491 санал буюу 11%-ийн саналаар С.Алимааг, кумулятив 174986 санал буюу 11%-ийн саналаар Ж.Болдбаатарыг, оролцогчдын кумулятив 180179 санал буюу 11%-ийн саналаар П.Оюунбаярыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн энгийн гишүүнээр, Кумулятив 174986 санал буюу 11%-ийн саналаар Б.Мэдрээг, кумулятив 174986 санал буюу 11%-ийн саналаар Билл Холдсвордыг, кумулятив 174986 санал буюу 11%-ийн саналаар И.Сэр-Одыг, кумулятив 182006 санал буюу 11%-ийн саналаар Т.Батмагнайг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр тус тус сонгох саналыг баталсугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн 174986 санал буюу 11%-ийн саналаар Компанийн 2025 оны удирдлагын зардлын төсвийг 4,200,000 /Дөрвөн сая хоёр зуун мянган/ төгрөгөөр батлах саналын дүнг тус тус баталсугай.
5. Хуралд оролцогчдын саналын хуудсаар өгсөн саналд явуулсан тооллогын дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулахыг Тооллогын комиссын дарга /Д.Даваасүрэн/-д даалгасугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

ГИШҮҮН

ГИШҮҮН

Д.ДАВААСҮРЭН

Б.МӨНХТУУЛ

Б.ЭНХДАРЬ